

Монгол Улс, БНСУ-ын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа, боломж

Даидаваагийн Мягмар

*Эрдэм шинжилгээний ажилтан,
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
myagmar_d@mas.ac.mn*

Хураангуй: Монгол Улс болон БНСУ-ын хөдөө аж ахуйн /ХАА/ салбарын өнөөгийн хамтын ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтран хэрэгжүүлдэг бага хэмжээний төсөл хөтөлбөрүүдээс хэтрэхгүй, хувийн хэвилүүдийн хамтын ажиллагаа дутмаг байдалтай байна. Хоёр улсын ХАА-н салбарын давуу сул талуудыг харьцуулан судалж үзэхэд харилцан үр ашигтайгаар хамтран ажиллах боломжууд харагдаж байна. Тиймээс улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөх Монгол Солонгосын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих нь зөв. Манай хоёр улс БНСУ болон дэлхийн зах зээлд эрэлт өндөр цөөн хэдэн төрлийн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамтран ажиллах боломжтой гэж үзсэний үндсэн дээр энэхүү өгүүллийн хүрээнд хамтын ажиллагааны хэд хэдэн хувилбар гаргасан.

Түлхүүр үгс: БНСУ, мал аж ахуй, газар тариалан, экспорт.



Оршил

Хүн амын өсөлтийг дагаад дэлхийн улс орнууд аажмаар хүнсний хомсдолд орж хүнс, ХАА-н бүтээгдэхүүний үнэ жил ирэх тусам нэмэгдэж байна. Хүнс, ХАА нь хүн амын эрүүл мэндтэй шууд холбогддог тул улс оронд стратегийн чухал ач холбогдолтой салбар юм. Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт экспортын 1.7 хувь нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, 3.8 хувь нь нэхмэл бүтээгдэхүүн, боловсруулсан арьс шир, 95 хувь нь байгалийн эрдэс түүхий эдээс бүрддэг.¹ Мөн Монгол Улсын нийт экспортын 70-аас дээш хувь нь зөвхөн БНХАУ-д ноогддог.² Эндээс харахад байгалийн баялгаас хэт хамааралтай эдийн засгаа төрөлжүүлэх, нөхөн сэргээгдэх баялгийн экспортыг нэмэгдүүлэх, мөн эдийн засгийн нэг улсаас хэт хараат байдлыг багасгах шаардлага Монгол Улсад тулгарч байна. Өргөн уудам газар нутагтай манай орны хувьд экспортод хамгийн өндөр боломж бүхий салбарын нэг бол хөдөө аж ахуй юм. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг /МАА/ хөгжүүлснээр Монгол орны бэлчээрийн доройтол болон цөлжилт буурах, нийслэл хот руу чиглэсэн иргэдийн урсгал багасгах, хэт төвлөрөл саарах, иргэдийн амьжиргаа дээшлэх, мөн ядуурлаас үүдэлтэй

нийгмийн олон сөрөг үзэгдлүүд буурах зэрэг олон давуу талтай. Өнөөгийн байдлаар Монгол Улсын ХАА-н салбарт тулгамдсан асуудал, хоцрогдсон зүйлс их байна. Эдгээр асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арга бол гадны хөрөнгө оруулалт, түүнийг дагасан орчин үеийн технологийг Монгол Улсад нэвтрүүлж ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх явдал юм. Монгол Улс болон БНСУ нь 1990 онд дипломат харилцаа тогтоосон цагаас хойш хоёр талт харилцааны маш өргөн хүрээний, гүн гүнзгий бааз суурьтай болсон. 2003 онд хоёр улсын Засгийн газар хооронд хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулснаар ХАА-н яамд хоорондын хамтын ажиллагаа идэвхэжсэн. 2004 оноос хоёр улсын Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны хурлыг хоёр жил тутамд хийх болсон. Уг хурлаар ХАА-н салбарт хамтран хийх үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж ирсэн ч хамтын ажиллагааны үр дүн нь боломжтойгоо харьцуулахад хангалтгүй байна. Манай хоёр улс харилцааны өнөөгийн бааз сууриа ашиглан ХАА-н салбарт давуу талаараа сул талаа харилцан нөхөх замаар аль аль талдаа үр ашигтай хамтран ажиллах өргөн боломж байна.

Нэг. Монгол Улс, БНСУ-ын ХАА-н хамтын ажиллагааны өнөөгийн байдал

1.1. Малын халдварт өвчний оношилгооны чиглэлээрх хамтын ажиллагаа

БНСУ-ын КОЙКА байгууллагын шугамаар 2004-2005 онд 0.4 сая долларын төсөв бүхий “Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний

эрүүл ахуйн лабораторийг бэхжүүлэх төсөл”, 2005-2006 онд 1.6 сая долларын санхүүжилттэй “Монгол Улсын малын гаралтай

¹ www.1212.mn

² www.1212.mn

бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг Улсын мал эмнэлгийн төв лабораторид тус тус хэрэгжүүлсэн. Шувууны томуу, шүлхий зэрэг гоц халдварт өвчнүүдийн оношилгоо, судалгааг сайжруулах зорилгоор БНСУ-ын КОЙКА байгууллагын буцалтгүй тусламжийн 1.3 сая долларын санхүүжилтээр “Малын вирусийн гаралтай өвчнийг оношлох био аюулгүйн 3-р зэрэглэлийн вирус судлалын лабораторийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дэргэд байгуулан 2008 оны 3 дугаар сард ашиглалтад оруулсан. Ингэснээр

шүлхий зэрэг вируст өвчнийг 24 цагийн дотор шуурхай оношлох, өвчин үүсгэгч вирусийг цэврээр ялган, нарийвчлан судалж өвчний үүсгэгчийн гарал үүсэл, хувьсал өөрчлөлтийг тогтоох үндэсний чадавх бүрдсэн. Түүнчлэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Солонгосын Үндэсний мал эмнэлгийн судалгаа, хорио цээрийн албаны хооронд 2002 оноос хойш малын халдварт өвчнийг оношлох арга зүй, мэдээлэл, мэргэжилтэн солилцох чиглэлээр хамтран ажиллаж ирсэн.

Хүснэгт 1. КОЙКА-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төслүүд³

	Төслийн нэр	Хугацаа	Олгосон санхүүжилт/\$	Хувь	Хэрэгжүүлэгч байгууллага
1	Багахангайн махны үйлдвэрийн зоорь барих	1993	300,000	3.3	ХХААЯ
2	Хүнсний бүтээгдэхүүний хор нян судлалын лаборатори байгуулах	1995	300,000	3.3	ХХААЯ
3	Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн лабораторийг бэхжүүлэх	2004-2005	400,000	4.3	ХХААЯ, МЭХ
4	Хүнсний ногооны хүлэмж байгуулах	2008-2009	1,400,000	15.2	ХХААЯ
5	Дорнод бүсийг хөгжүүлэх ХАА-н Мастер төлөвлөгөө	2008-2009	2,500,000	27.1	ХХААЯ
6	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн тогтолцоог шинэчлэх	2008-2010	1,700,000	18.5	ХХААЯ, МЭХ
7	ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх	2013-2015	1,000,000	11	ХХААЯ
8	Экологид ээлтэй ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл	2013-2015	1,600,000	17.4	ХХААЯ, ХААИС
	НИЙТ САНХҮҮЖИЛТ		9,200,000	100	

КОЙКА-ийн санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлсэн нийт төслийн төсөвт өртгийн 9 орчим хувь буюу 9.2 сая долларыг ХАА-н салбарт зарцуулсан. Үүнээс малын халдварт

өвчний оношилгоо, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулахад 37.1 хувь, үлдсэн хэсгийг ХАА-н үйлдвэрлэл болон судалгааны чиглэлээр зарцуулсан байна.

³ ГХТА. Х-112, ХН-195, х.1-6.

1.2. Халх голын бүс дэх хамтын ажиллагаа

2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хийсэн дээд хэмжээний айлчлалаар БНСУ-ын талтай Монголын зүүн бүсийг хөгжүүлэх “Дорнод Монгол” төсөл, түүний техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, газар тариалан хөгжүүлэх талаар Монгол Улсын ХХААЯ, БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн корпорацын хооронд хамтран ажиллахаар тохиролцсон.⁴ Уг тохиролцооны дагуу 2008-2009 онд Дорнод аймгийн Халхгол сумын газар тариаланд ашиглах боломжтой 270.000 га талбайг хамарсан хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх иж бүрэн мастер төлөвлөгөө, 200 га талбайд мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуй байгуулах зураг төслийг тус тус боловсруулсан. Төслийн хоёрдугаар үе шат болох нийт 4,0 сая долларын санхүүжилт бүхий “Халх голд загвар аж ахуй байгуулах” төслийн баримт бичигт 2011 онд гарын үсэг зурсны дагуу 200 га талбайд

усалгааны систем байгуулан, малын тэжээл, бусад таримлыг тариалах, сүүний үхрийн загвар ферм байгуулах ажлыг хийж гүйцэтгэж байсан ч үр дүнд хүрээгүй. Иргэдийн дунд солонгосчуудад урт хугацаагаар Монголын газар нутгийг түрээслүүлэх гэж байна гэх хардлага төрүүлж эсэргүүцэлтэй тулгарснаар энэхүү төсөл зогсонги байдалд орсон.

Одоогийн байдлаар “Халх Гол Үндэсний бүтээн байгуулалтын бүс”-д Солонгосын хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хэрэгжүүлдэг КАРЕХ (Korean Agricultural Policy Experiences for Food Security) хөтөлбөрийн хүрээнд “Монгол улсын зүүн бүсийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэмүү өртгийг дээшлүүлж, экспортын чадавхыг бэхжүүлэх”, БНСУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яамтай “Орчин үеийн мал төхөөрөх үйлдвэр байгуулах” зэрэг төслүүд судалгааны шатандаа явж байна.

1.3. “КОПИА Монгол” төвийн үйл ажиллагаа

БНСУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөөгийн хөгжлийн удирдах газар /КОПИА/ нь 2009 онд тус улсын Ерөнхийлөгчийн шууд удирдлага дор байгуулагдсан бөгөөд Ази, Африк, Өмнөд Америкийн хөгжиж буй 22 улсад салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. КОПИА нь хөгжиж буй орнуудад БНСУ-ын ХАА-н технологи дамжуулах сургалт, судалгаа, мөн хүнсний ногоо, таримал ургамал, малын тэжээл тариалах, чанарыг сайжруулах туршилтын

төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээрийн дундаас өндөр өгөөж, үр дүнтэй төсөл хөтөлбөрийг сонгон санхүүжилт хийж жишиг ферм бий болгох замаар орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах ажлуудыг хэрэгжүүлж байна. “КОПИА Монгол” төв нь 2014 онд үйл ажиллагаагаа эхэлсэн цагаас хойш Монгол орны хүнсний ногоо, таримал ургамал, малын тэжээлийн чанар, гарцыг сайжруулах болон сургалт судалгааны чиглэлээр ХХААХҮЯ, ХААИС-тай хамтран 1,4 сая

⁴ ГХТА. Х-112, ХН-92, х.132-134.

долларын 14 төрлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнээс малын тэжээл тарих, үйлдвэрлэх төслийн үзүүлэлт, үр дүн өндөр гарсан тул 2022-2025 онд “Малын тэжээл

үйлдвэрлэх загвар сум байгуулах” 1,5 сая долларын өртөг бүхий төслийг Монгол Улсын төвийн бүсийн нэг суманд хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

1.4. БНСУ-ын Кангвон болон Кёнсанбуг мужтай хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа

2003 онд ХХААЯ, БНСУ-ын Кангвон муж хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Төв аймгийн Зуунмод хот, Борнуур, Баянчандмань сумдад Кангвон мужийн хөдөө аж ахуйн төв буюу хүлэмжийн загвар аж ахуйнуудыг байгуулсан нь хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмж эрхлэгчдэд Солонгосын дэвшилтэт технологийг таниулан сурталчлахад үлэмж хувь нэмэр оруулсан. Мөн Кангвон аймаг ХААИС хоорондын хамтын ажиллагааны хүрээнд олон улсын хөдөө аж ахуйн технологи дамжуулах хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна. “Монголын хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сургалтын төслийг 2016-2019 он хүртэл хэрэгжүүлсэн. 2016 онд нийт 4 удаагийн сургалтад 230 гаруй агрономичдыг хамруулан гүзээлзгэнэ, тарвас, өргөст хэмх, лооль, чинжүү болон хулуу тарих эрчимжсэн сургалтыг амжилттай зохион байгуулсан. 2009 онд ХХААХҮЯ болон БНСУ-ын Кёнсанбуг муж хооронд хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулан хүлэмж, хүнсний ногооны тариалалтын чиглэлээр Монголын 40 орчим хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, фермерүүдийг Кёнсанбуг мужид дадлагажуулан сургасан. Одоо ХААИС, БНСУ-ын Кёнсанбуг аймгийн Хөдөө аж ахуйн

технологийн хүрээлэнтэй хамтарсан “Хүнсний ногоо нутагшуулах, ашигт ургамлыг тарималжуулах” олон улсын хамтарсан төслийг хэрэгжүүлж байгаа ба гурван лабораторийг багаж тоног төхөөрөмжөөр хангасан.

Хоёр улсын ХАА-н салбарын өнөөгийн хамтын ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллагууд тодорхой зорилго бүхий Монгол Улсад шаардлагатай бага хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт хийх, мэргэжилтэн солилцох зэрэг хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж ирсэн нь харагдаж байна. Нөгөөтээгүүр улс оронд эдийн засагт бодит үр өгөөжөө өгөх хоёр талын хувийн хэвшлийн хамтын ажиллагаа үгүйлэгдэж байна. Өнөөг хүртэл БНСУ-ын талаас Монгол Улсын ХАА-н салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийгдээгүй. Тэд Монгол Улсыг газар тариалан эрхлэх хугацаа богино, дэд бүтэц сул хөгжсөн, төр засгийн бодлого тогтворгүй, ажиллах хүчний хөдөлмөрийн бүтээмж бага зэрэг шалтгаанаар хамтран ажиллахаас зайлсхийдэг. Гэвч энэ нь хамтран ажиллах сонирхол огт байхгүй гэсэн үг биш. 2007 онд Монгол орны Халх голын сав газарт томоохон хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллахаар төлөвлөж байсан нь үүгээр харагддаг.

**Хоёр. Монгол Улс, БНСУ-ын ХАА-н салбарт тулгамдаж буй асуудлууд,
харилцан нөхөх, хамтран ажиллах боломжууд**

Монгол Улсын ХАА-н салбар нь 2020 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 12.8 хувийг⁵ эзэлж байна. Монгол Улсын нийт мал сүргийн тоо толгой сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байгаа ч үүнийг дагаад бэлчээрийн хомсдол, цөлжилт, малын гаралтай халдварт өвчин нэмэгдэж, нэг малаас авах ашиг шим буурч байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гарц нь малын тоо толгойноос илүү чанарыг сайжруулах буюу газар тариаланг өндөр ашиг шим бүхий эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх явдал гэж үзэн, энэ чиглэлийг хөгжүүлэхэд төрийн зүгээс анхаарч ажиллаж байна. Гэвч 2020 оны байдлаар Монгол Улсын өндөр ашиг шимтэй, эрчимжсэн аргаар өсгөн үржүүлдэг мал сүргийн тоо нь нийт мал сүргийн тооны нэг хувьд хүрэхгүй байна.⁶ Манай улсын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц бололцоо их боловч стандартын шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэж чаддаггүйн улмаас хөгжингүй орнуудад экспортолж чаддаггүй.

Газар тариалангийн салбарт ч тулгамдсан асуудлууд их. Монгол Улс өнөөгийн байдлаар нийт газар нутгийн 0.5 хувьд нь газар тариалан эрхэлдэг.⁷ Хүнсний нарийн ногоо болон жимс жимсгэний дотоодын хэрэглээний дийлэнх хувийг импортоор бүрдүүлж байна. Нарийн ногоо, жимс жимсгэний импортын орон зайг нөхөж дотоодод хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх шаардлага өндөр байна. Үр тарианы үнийг төрөөс зах зээлийн бодит ханшаас доогуур хэмжээнд хүчээр тогтоон барьж, улмаар үр тариа үйлдвэрлэгчдэд их хэмжээний татаас өгч ирсэн. Энэ нь ард иргэдийн амьжиргааг дэмжих зорилготой боловч үнийг хүчээр тогтоон барьснаараа уг салбарын зах зээлийн жамаар хөгжих боломжийг хязгаарлаж, уг салбарт эмх цэгцгүй байдлыг бий болгодог. Мөн гадны хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй байдал төрүүлдэг. Тиймээс үр тарианы үйлдвэрлэлд төрийн оролцоог багасгах, мөн гадны өндөр технологи нэвтрүүлж үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдүүлэх шаардлага байна.

⁵ www.1212.mn

⁶ Эрчимжсэн мал аж ахуй - ХХААХҮЯам (mofa.gov.mn)

⁷ Эдэлбэр газар - ХХААХҮЯам (mofa.gov.mn)

Хүснэгт 2: МAA-н салбарт харилцан нөхөх боломж

(тод хараар давуу талыг тэмдэглэв)

МAA-н салбарын давуу ба сул талууд	
Монгол Улс	БНСУ
1 Эрчимжсэн МAA-н үйлдвэрлэлийн хэмжээ маш бага, бэлчээрийн маллагаатай	МAA-н үйл ажиллагаа бүрэн эрчимжсэн хэлбэрээр явагддаг, суурин маллагаатай
2 Малын тоо толгойн хэт өсөлт, цаг уурын өөрчлөлтөөс үүдэн бэлчээрийн доройтол, цөлжилт нүүрлэсэн	Малыг 100 хувь таримал өвс ургамал, бордоогоор тэжээдэг
3 Мал амьтны гаралтай халдварт өвчин элбэг, малын эрүүл ахуйн стандарт тааруу	Малын эрүүл ахуйг сайтар сахидаг, вакцинжуулалт тогтмол явагддаг
4 Цөөн хэдэн ААН-ээс бусад нь малын бүртгэл хийдэггүй	Малын бүртгэлийн мэдээллийн бааз суурь бий болгосон, малын өвчний түүх, вакцинжуулалт, онцлог, удмын сангийн мэдээлэл зэргийг бүртгэдэг
5 Эрчимжсэн МAA-г хөгжүүлснээр малын бэлчээрийн өргөн уудам талбайг өвс хадлан бэлтгэх, тэжээл бордоо тариалах зориулалтаар ашиглах боломжтой	Газрын хүрэлцээ, ажиллах хүчний хомсдол, малын тэжээл бордооны өндөр үнэ зэргээс шалтгаалан дотоодын малын махны үнэ хэт өндөр байдаг
6 Дотоодын махны хэрэгцээг бүрэн хангадаг төдийгүй экспорт хийх өргөн боломжтой	Дотоодын махны үйлдвэрлэлийн хэмжээ бага, үнэ өндөр учир их хэмжээний мах, махан бүтээгдэхүүнийг импортоор авч хэрэглэдэг
7 Мал нядалгаа, мах бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт шаардлага сул, эрүүл ахуйн тулгамдсан асуудал их	Мал нядалгааны үйлдвэрүүд нь бүрэн механикжсан, мах бэлтгэл, боловсруулалт, тээвэрлэлтийн эрүүл ахуйн стандарт нь хэвшсэн

БНСУ 1963 оноос орчин үеийн технологид тулгуурласан аж үйлдвэрлэлийг хөгжлийн замаар сонгосноос хойш ХAA-н салбарын үйлдвэрлэл үндсэндээ орхигдсон. 2019 оны байдлаар ХAA эрхлэгчдийн тоо 2.2 сая болтлоо буурч, дундаж нас 59 байгаа бол тэдний 35 хувийг 65 буюу түүнээс дээш насныхан⁸ эзэлж байна. Тиймээс ХAA-н салбартаа олон тооны гадаад ажилчин авч ажиллуулдаг. Хот суурин, үйлдвэрийн газар нэмэгдэхийн хирээр ХAA-н эдэлбэр газрын хэмжээ жил тутам буурч байгаа бөгөөд 1990 онд 2.1 сая га байсан бол 2020 онд 1.5 сая га⁹ болсон ба цаашид ч буурах төлөвтэй байна. Үүнээс шалтгаалан газрын үнэ ямагт өндөр байдгийн дээр ХAA-н машин, тоног

төхөөрөмжийн үнэ, ажиллах хүчний өртөг өндөр байдал нь уг салбарын үйлдвэрлэлийн хомсдолын үндсэн шалтгаан болдог. Нэгж талбайгаас жилд 2 удаа ургац авдаг бөгөөд газрыг амрааж, сэлгэн тариалалт хийдэггүй учир газар тариаланд ихээхэн хэмжээний бордоо ашигладаг. Мөн цагаан будааны тариалалтыг нэмэгдүүлснээс болж сүүлийн жилүүдэд хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн хэмжээ буурсан. Дээр дурдсан шалтгаануудаас үүдэн тус улсын ХAA-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл жил тутам буурч байгаа бөгөөд импортын хэрэглээ тасралтгүй нэмэгдэж байна. 2019 оны байдлаар хүнсний хэрэглээний 45 хувийг импортоор нөхөж байгаа бөгөөд 27.5

⁸ 행정구역(시군구)별 농가, 농가인구 (kosis.kr)

⁹ KOSIS 국가통계포털

тэрбум долларын ¹⁰ хүнсний бүтээгдэхүүн технологийг мэдээллийн технологитой импортолсон байна. Үүнд үхэр, гахай, тахианы хослуулах замаар ХАА-н ухаалаг мах, жимс, улаан буудай, эрдэнэ шиш гол байр үйлдвэрлэлийг хөгжүүлж байна. Одоогоор эзэлж байна. Сүүлийн үед ажиллах хүчний дотоодын ухаалаг ХАА-н үйлдвэрлэлийн хомсдол, үйлдвэрлэлийн өндөр өртгийн хэмжээ нь нийт үйлдвэрлэлийн маш бага хувийг асуудлыг ухаалаг технологи ашиглан эзэлж байгаа ч ихээхэн ирээдүйтэй гэж тус шийдвэрлэхээр зорьж байна. Биологи, физик, улсын эрдэмтэд үздэг. химийн шинжлэх ухаан, инженерийн

Хүснэгт 3: Газар тариалангийн салбарт харилцан нөхөх боломж
(тод хараар давуу талыг тэмдэглэв)

Газар тариалангийн салбарын давуу ба сул талууд	
Монгол Улс	БНСУ
1 Нийт газар нутгийн 0.5 хувьд газар тариалан эрхэлдэг, үүнийг нэмэгдүүлэх боломжтой	Нийт газар нутгийн 7 орчим хувьд нь газар тариалан эрхэлдэг бөгөөд цаашид энэ тоо буурах төлөвтэй
2 Нэгж газраас жилд нэг удаа ургац авдаг, газар сэлгэн тариалдаг, бордооны хэрэглээ бага	Нэгж газраас жилд 2 удаа ургац авдаг, бордоо их хэмжээгээр хэрэглэдэг
3 Газар өвөлдөө бүрэн хөлддөг учир нян бактери бага үрждэг, эрүүл хөрстэй	Хөрсийг эрүүлжүүлэх, нян бактери үржихээс сэргийлж ариутгалын бодис их ашигладаг
4 Газрын болон ажиллах хүчний үнэ хямд, гагцхүү орчин үеийн тоног төхөөрөмж, өндөр технологи, хөрөнгө оруулалт шаардлагатай	Газар, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн үнэ өндөр байдгаас үүдэн дотоодын үр тариа, хүнсний ногооны үнэ өндөр, хүртээмж бага
5 Усалгаатай тариалангийн хэмжээ бага, байгаль цаг уурын нөлөөнд өртөмхий	Шуудуун болон автомат усалгааны системийг ашигладаг, байгаль цаг уурын нөлөөнд бага өртдөг
6 Тоног төхөөрөмжүүдийн дийлэнх нь хоцрогдсон учир шинэчлэх, мөн уламжлалт арга барилаа сайжруулах, үйлдвэрлэлд шинэ, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх шаардлагатай	Газар тариалангийн үйлдвэрлэлд автоматжуулалт, механикжуулалт ихээхэн хөгжсөн, мөн цаашид ХАА-н үйлдвэрлэлд хүний оролцоог багасгах төрөл бүрийн ухаалаг технологи, удирдлагын системийг хөгжүүлж байгаа

БНСУ дахь газрын үнэ, газрын хүртээмж, ажиллах хүчний хомсдол, түүнээс үүдсэн дотоодын хүнсний бараа бүтээгдэхүүний өндөр өртөг зэрэг тулгамдсан асуудал нь хамтын ажиллагааны хүрээнд өргөн уудам нутагтай Монгол Улсад шийдвэрлэх бүрэн боломжтой. Нөгөөтээгүүр Монгол Улсад тулгамдаж буй технологийн хоцрогдол, үйлдвэрлэлийн

бүтээмж, байгаль цаг уурын нөлөөнд өртөмхий байдал зэрэг асуудлыг БНСУ-ын хөрөнгө оруулалт, техник технологи болон үр ашигтай хамтын ажиллагаагаар дамжуулан шийдвэрлэх боломжтой нь харагдаж байна. Английн эдийн засагч Давид Рикардгийн эдийн засгийн харьцангуй давуу талын онолын дагуу хамтран ажиллахаар зорьж буй улсын капитал, газар,

¹⁰ e-나라지표 지표조회상세 (index.go.kr)

хөдөлмөр, байгалийн баялаг зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг ашиглан зорилтот бүтээгдэхүүнийг өөрийн орноос илүү ашигтай, хямд өртгөөр үйлдвэрлэх боломжтой бол харьцангуй давуу талтай гэж үздэг. Монгол Улсын ХАА-н үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйлс болох газар болон ажиллах хүч нь БНСУ-аас олон дахин хямд өртөгтэй учир харьцангуй давуу тал байна. Үүнээс гадна газарзүйн байршлын хүчин зүйлийг авч үзэх ёстой. Газарзүйн байршлын хувьд Монгол Улстай хамтран ажиллахад БНХАУ нь Монгол Улстай хиллэдэг учир БНСУ-аас хавьгүй илүү давуу талтай. БНХАУ нь БНСУ-ын нэгэн адил дотоодын нөөц бололцоогоор хүн амын хүнсний

хэрэгцээг хангах боломжгүй болсон учир Бүс ба зам санаачилгын хүрээнд Ази, Африкийн 23 улсад ХАА-н чиглэлийн 63 хамтарсан төсөл хэрэгжүүлж байна.¹¹ Гэвч бид эдийн засгийн хувьд ихээхэн хараат байдалтай байдаг БНХАУ-тай ХАА-н салбарт хамтран ажиллах нь Монгол Улсын эрх ашигт нийцэхгүй. ОХУ нь өргөн уудам газар нутагтай, үр тариа болон ХАА-н олон төрлийн бүтээгдэхүүний дэлхийн хэмжээний нийлүүлэгч улс учир Монгол Улстай хамтран ажиллах сонирхол бага. Тиймээс БНСУ зэрэг гуравдагч хөрш орнуудтай ХАА-н салбарт хамтран ажиллах нь Монгол Улсын эрх ашигт нийцнэ.

Хүснэгт 4: БНСУ-ын зарим хүнсний бүтээгдэхүүний импортын үнийн дүн (2020 он)¹²

№	Барааны нэр	Үнийн дүн \$
1	Улаан буудай	970.450.000
2	Эрдэнэ шиш	2.371.000.000
3	Үхрийн ястай мах	802.658.000
4	Үхрийн цул мах	1.077.899.000
5	Гахайн мах	1.279.829.000
6	Цагаан архи, спирт	185.892.000

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсад үйлдвэрлэдэг 6 төрлийн хүнс, ХАА-н бүтээгдэхүүнийг БНСУ нь гадны улсуудаас их хэмжээгээр импортоор худалдан авч хэрэглэж

байна. Эдгээрээс зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд манай хоёр улс хамтран ажиллах боломжтой.

Эрчимжсэн мал аж ахуйн салбарт хамтран ажиллах боломж

БНСУ-ын талаас Дорнод аймгийн Халхгол суманд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр манай улстай хамтран ажиллах сонирхол өндөр байдаг. Халхгол

суманд Монгол Улсын ХХААХҮЯ-аас БНСУ-ын талтай хамтран эрчимжсэн мал аж ахуйн чиглэлийн 2 төрлийн төслийн судалгааг одоогоор хийж байгаа. Халх голын сав газар нь

¹¹ An Analysis of the Influencing Factors in the Establishment of the Overseas Agricultural Cooperation

Zones under the Belt and Road Initiative Based on Logit Model (hindawi.com)

¹² www.trademap.org

газарзүйн байршлын хувьд БНСУ-тай ойр, ОХУ, БНХАУ-ын зах зээлд шууд гарцтай, хөрсний үржил шимт байдал зэрэг давуу талууд нь солонгосчуудын сонирхлыг ихээр татдаг. Бид энэ бүсэд эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээл тариалалт, малын тэжээлийн үйлдвэрлэл, мах боловсруулалт, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл зэрэг чиглэлээр хөрөнгө оруулалт татаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой. Уг бүсэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг БНСУ-аас гадна ОХУ, БНХАУ-ын зах зээлд шууд гаргах боломжтой. Манай улс малын гаралтай шүлхий, галзуу зэрэг олон төрлийн халдварт өвчний идэвхтэй бүсэд байдаг, дээр нь малын бүртгэлийн системгүй учир Монгол Улсаас гаралтай мах, махан бүтээгдэхүүнд БНСУ-ын талаас дунджаар 72 орчим төрлийн импортын хориг, шалгуур тавьдаг. Импортын хориг шалгуурыг даван туулах арга зам бол малыг (үхэр) хязгаарлагдмал орчинд фермерийн аргаар 100 хувь тэжээж өсгөх явдал юм. Мөн малыг төрсөн

цагаас нь удмын мэдээлэл, эрүүл мэндийн байдал, вакцинжуулалт, өсөлтийн явцыг бүртгэж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох шаардлагатай. Эдгээр ажлууд нь манай улсын хувьд шинэ зүйл боловч БНСУ-д нэгэнт хэвшин тогтсон. Өөрөөр хэлбэл тэд хэрхэн яаж малыг эрүүлжүүлэх, удмын санг хөтлөх, бүртгэлжүүлэх, аюулгүй өсгөж үржүүлэх арга олсон. БНСУ-ын талаас хөрөнгө оруулалт татан хамтран ажиллаж тэдний технологи, эрүүд ахуйн стандарт шаардлагуудыг Монгол Улсад нэвтрүүлснээр дээрх ажлууд нь биеллээ олох, улмаар махны экспортын үүд хаалга нээгдэх боломжтой. Мал аж ахуйн халдваргүй бүсийг (аль нэг сум, эсвэл хил хязгаарыг тодорхой тогтоосон бүс) бий болгож, импортын хориг стандартуудыг хангаж чадвал БНСУ төдийгүй дэлхийн бусад орнуудад ч экспорт хийх боломж нээгдэнэ. Энэ нь өөрөө цаг хугацаа, хичээл зүтгэл, их хэмжээний хөрөнгө шаардсан хүнд ажил боловч ирээдүйд хүртэх өгөөж нь арвин их.

Улаан буудай, эрдэнэ шиш тариалалтад хамтран ажиллах боломж

Дэлхийн хүн амын өсөлтийг дагаад улаан буудай, эрдэнэ шишийн үнэ, эрэлт жил ирэх тутам нэмэгдэж байгаа. БНСУ нь 2020 онд асар их хэмжээний улаан буудай, эрдэнэ шишийг гадаад орнуудаас импортоор авсан нь хүснэгт 4-өөс харагдаж байна. Тус улсын гадны улсуудаас импортоор авдаг улаан буудай, эрдэнэ шишид гений өөрчлөлт илэрдэг. Гений өөрчлөлттэй импортын хүнсний бүтээгдэхүүнийг БНСУ-ын ард иргэд үе үе эсэргүүцэн тэмцдэг ч удалгүй намждаг. Монгол Улс нь улаан буудай тариалах уламжлалт арга барил, олон жилийн

туршлагатай боловч үйлдвэрлэлийн хэмжээ нь дотоодын хэрэгцээнээс хэтрэхгүй байна. Эрдэнэ шиш нь говийн хөрсөнд сайн ургадаг боловч үүнийг монголчууд хүнсэнд бус малын тэжээлд түлхүү хэрэглэдэг. Улаан буудай, эрдэнэ шишийн экспорт хийхийн тулд үйлдвэрлэлийг их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг өсгөхийн тулд усалгаатай тариалалт хийх, шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатай. Говийн бүсийн мега төслүүдийг усаар хангах Хөх морь төсөл хэрэгжвэл Халхгол,

Төв-Сэлэнгийн бүс гэлтгүй Говийн бүсэд энэ чиглэлээр хамтран ажиллаж болно. Хүнсний улаан буудай, эрдэнэ шишийг өндөр бүтээмжтэй тариалах, боловсруулахад БНСУ-ын хөрөнгө оруулалт, технологийг татах, хамтран ажиллах,

улмаар гений өөрчлөлтгүй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох боломж байна. Улаан буудай эрдэнэ шишийн хувьд тус улсын зүгээс тавигддаг импортын хориг шалгуур харьцангуй цөөн.

Мал төхөөрөх үйлдвэр байгуулах, махны эрүүл ахуй салбарт дахь боломж

Махны үйлдвэрлэлийн эрүүл ахуй нь монгол хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой тулгамдсан асуудлуудын нэг юм. Экспортын махыг стандарт эрүүл ахуйн шаардлагын дагуу бэлтгэдэг атал дотоодын хэрэглээний мах бэлтгэлд ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал доголдолтой байна. Солонгосын мал төхөөрөх, мах бэлтгэх үйлдвэрүүд нь хүний оролцоо бага, үйлдвэрлэлийн автомат процесс дамжлагуудтай, мах нь үйлдвэрлэгчээс хэрэглэгчийн гарт очих хүртэлх ажиллагаа нь

нэгэн загварт орж хэвшсэн, эрүүл ахуйн асуудал бага гардаг. Монгол Улсын Засгийн газраас идэвх зүтгэл гарган БНСУ-ын мал төхөөрөх үйлдвэр, махны эрүүл ахуйн технологи туршлагыг Монголд нэвтрүүлбэл ард түмний эрүүл мэндэд ач тусаа өгнө. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хууль эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэн өгөх, мөн бизнесийн үйл ажиллагааны төрөл бүрийн хөнгөлөлт, зөвшөөрөл олгох хэлбэрээр дэмжиж өгч болно.

Чацаргана, зөгийн бал үйлдвэрлэлд хамтран ажиллах боломж

Солонгосын эрдэмтэд монгол зөгийн бал болон чацаргана жимсийг олон жилийн өмнөөс судалж ач тусыг нь мэддэг болсон. Монгол зөгийн бал, чацаргана нь эрс тэс уур амьсгалын нөлөөгөөр, байгалийн антиоксидант буюу хордлого тайлах чанар өндөр, амин дэмийн агууламж их байдаг нь тэдний сонирхлыг татдаг. 2020 онд БНСУ-ын Ихва их сургуулийн эрдэмтэд корона вирусийг дарангуйлдаг бактерийг чацарганаас илрүүлсэн¹³. 2019 оноос Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газар, БНСУ-ын Ногоон Ази төрийн бус байгууллага хамтран

КОЙКА-ийн санхүүжилтээр жилд 600 тонн чацаргана боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр барьж ашиглалтад оруулсан. Энэ нь тэдний уг салбарт хамтран ажиллах сонирхол байгааг илэрхийлдэг. Монгол чацарганын шүүс болон зөгийн балыг БНСУ-д бага хэмжээгээр экспортолж байсан боловч эдгээр бүтээгдэхүүний онцлог, давуу тал, ашиг тусыг тус улсын хэрэглэгчдэд таниулах маркетинг байхгүй, мөн чацарганын шүүсийг тус улсын хэрэглэгчдийн зан төлөв, таашаалд нийцүүлж чадаагүйгээс болж экспортод амжилт олоогүй.

¹³ [이대서울병원 천연물에서 코로나 19 바이러스 억제물질 발견 | 한경닷컴 \(hankyung.com\)](http://www.hankyung.com)

Зөгийн бал, чацаргана тариалах, боловсруулах үйлдвэрлэлд БНСУ-ын хөрөнгө оруулалт, технологийг татаж хамтран ажилласнаар эцсийн

бүтээгдэхүүнийг тус улсын хэрэглэгчдийн хүсэл таашаалд нийцүүлэн үйлдвэрлэх боломжтой.

Нарийн ногоо, жимсний хүлэмжийн аж ахуйн салбарт хамтран ажиллах боломж

Монгол Улсад нарийн ногооны өвөл, зуны хүлэмжийн тоо цөөн, импортын хэрэглээ хэт өндөр байна. Хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд зуны нийлэг хальсан хүлэмж барих, ашиглах технологи Монголд нэлээд эрчимтэй нэвтэрч байгаа ч хүлэмжийн тоо, үйлдвэрлэлийн хэмжээ хангалтгүй байна. Хүлэмжийн аж ахуй эрхлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй дотоодын аж ахуйн нэгжүүд олон байдаг.

Одоогоор БНСУ-ын хөрөнгө оруулалттай хоёр томоохон хүлэмжийн аж ахуй И-мартын салбаруудад нарийн ногоо, жимс нийлүүлж байна. Цаашид хүлэмжийн аж ахуйд БНСУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёр улсын жижиг дунд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг бодлогоор дэмжиж өгвөл хөгжлийн өргөн боломж байна.

Accepted Manuscript

Дүгнэлт

Хоёр улсын ХАА-н салбарын давуу сул талуудыг харьцуулан судлахад Монгол Улсад ХАА-н үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйлс болох газар болон ажиллах хүчний өртөг БНСУ-аас хэд дахин хямд, Монгол Улсад дутагдаж буй капитал, ХАА-н орчин үеийн дэвшилтэт технологи, стандарт БНСУ-д байгаа нь хоёр улс уг салбарт харилцан үр ашигтай хамтран ажиллах боломжтойг харуулж байна. ХАА, хүнсний үйлдвэрлэлийн аливаа хэлбэрийн хамтын ажиллагаанд бид хоёр хөршөөс илүүтэй БНСУ зэрэг гуравдагч хөрш орнуудтай хамтран ажиллах, тэдний хөрөнгө оруулалтыг татах нь Монгол Улсад тустай. Одоогоор Солонгосын талаас ХАА-н салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийгээгүй ч Монгол Улстай хамтран ажиллах сонирхол их байдаг нь Дорнод аймгийн Халхгол суманд явагдаж буй хамтын ажиллагаа, мөн БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн удирдах газар Монгол Улсад салбараа нээн ажиллуулж байгаагаар харагддаг. Бид БНСУ-тай хүнс, ХАА-н үйлдвэрлэлд хамтран ажилласнаар тус улсын технологи, ноу-хау, стандарт шалгууруудыг Монгол Улсад нутагшуулах боломж бүрдэнэ. Орчин үеийн технологиор

дэлхийн стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадвал Нэгт БНСУ гэлтгүй бусад орнуудад экспортлох үүд хаалга нээгдэнэ, Хоёрт экспортын үйлдвэрлэлийн потенциалыг /массаар тууштай, тасралтгүй үйлдвэрлэх/ бий болгож болно. Эдгээр нь бидний БНСУ-тай хийх ХАА-н салбарын хамтын ажиллагаанаас хүлээх үр дүн, Монгол Улсад үлдэх давуу юм. Сэдвийн хүрээнд БНСУ төдийгүй дэлхийн хэмжээнд эрэлт нь тасралтгүй нэмэгдэж байгаа ч нийлүүлэлт нь хязгаарлагддаг хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүнүүд болох мах, улаан буудай, эрдэнэ шиш, мөн Монгол орны онцлог бүхий чацаргана, зөгийн бал, түүнчлэн Монгол Улсад нэн шаардлагатай байгаа хүлэмжийн аж ахуй, мал нядалгааны үйлдвэр байгуулах гэсэн цөөн хэдэн чиглэлээр хамтран ажиллах боломжтой гэж үзсэн. Хамтын ажиллагааны боломжийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд тэдэнд хөрөнгө оруулах, тууштай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх ёстой. Үүнийг бид дотооддоо ХАА-н хамтын ажиллагааны экспортын үйлдвэрлэлийн тусгай бүс байгуулах зэрэг аргаар хуульчлан шийдвэрлэх боломжтой.

Эх сурвалж

1. Гадаад харилцааны төв архив.
2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn
3. ХХААХҮЯ-ны цахим хуудас. <https://mofa.gov.mn/>
4. Засгийн газраас “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр баталлаа | МОНГОЛЫН ЖИМС ЖИМСГЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОЛБОО ТББ (chatsargana.mn)
5. БНСУ-ын Статистикийн төв газрын цахим хуудас. KOSIS 국가통계포털
6. БНСУ-ын Гаалийн газрын цахим хуудас. [수출입 무역통계 \(customs.go.kr\)](http://수출입 무역통계 (customs.go.kr))
7. БНСУ-ын тоон үзүүлэлтийн вэб хуудас. [e-나라지표 지표조회상세 \(index.go.kr\)](http://e-나라지표 지표조회상세 (index.go.kr))
8. Дэлхийн эдийн засгийн тоон мэдээллийн вэб хуудас. [Korea : GDP Composition Breakdown \(mecometer.com\)](http://Korea : GDP Composition Breakdown (mecometer.com))
9. БНСУ-ын эдийн засгийн мэдээллийн портал сайт. [이대서울병원 천연물에서 코로나 19 바이러스 억제물질 발견 | 한경닷컴 \(hankyung.com\)](http://이대서울병원 천연물에서 코로나 19 바이러스 억제물질 발견 | 한경닷컴 (hankyung.com))
10. Олон улсын худалдааны төвийн худалдааны статистикийн цахим хуудас. www.trademap.org
11. Олон улсын худалдааны төвийн улс хоорондын худалдааны хориг саадыг харах цахим хуудас. www.masmap.org
12. Албани Улсын ХАА, хөрөнгө оруулалтын чөлөөт бүсийн тухай. Agriculture | Albania Freezone
13. АНЭУ-аас Африк тивийн Уганда улстай ХАА-н чөлөөт бүсэд хамтран ажиллаж буй тухай [UAE and Uganda to establish one of the world's first agricultural free zones \(thenationalnews.com\)](http://UAE and Uganda to establish one of the world's first agricultural free zones (thenationalnews.com))
14. БНХАУ-аас Бүс ба Зам санаачилгын хүрээнд дэлхийн улс орнуудтай хэрэгжүүлж буй ХАА-н хамтын ажиллагааны тухай [An Analysis of the Influencing Factors in the Establishment of the Overseas Agricultural Cooperation Zones under the Belt and Road Initiative Based on Logit Model \(hindawi.com\)](http://An Analysis of the Influencing Factors in the Establishment of the Overseas Agricultural Cooperation Zones under the Belt and Road Initiative Based on Logit Model (hindawi.com))

Agricultural cooperation opportunity between Mongolia and Korea

Myagmar Dashdavaa

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia*

myagmar_d@mas.ac.mn

Abstract: The agricultural cooperation between Mongolia and South Korea lacks collaboration between the private sectors and is limited to only small-scale projects of governmental and non-governmental organizations at this time. Studying the agricultural cooperation between the two countries shows possible collaboration opportunities with potentially beneficial results for both Mongolia and South Korea. Therefore, for the benefit of the national economy, a collaboration between the private sectors of Mongolia and South Korea should be supported by the government. Assuming that the collaboration between the two countries on the production of highly demanded agricultural products in both the South Korean and the world market is potential, several versions of collaborating opportunities are demonstrated.

Key words: *Korea, livestock husbandry, agriculture, export.*

The day of submission: 2022.04.13

Completion of review: 2021.05.20

Final decision for acceptance: 2022.06.20